



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар А - 247

Улаанбаатар хот

“Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратеги 2024-2030” батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5.1.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 65 дугаар тогтоолын 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1.“Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратеги 2024-2030”-ийг хавсралтаар баталсугай.
- 2.“Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратеги 2024-2030”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Олон нийтийн санхүүгийн боловсролын төв (Б.Одонтунгалаг)-т үүрэг болгосугай,
- 3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (А.Шижирмаа)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН



Монголбанкны Ерөнхийлөгчийн 2023 оны
12 сарын 26-ний өдрийн ... бугаар
түшцаалын хавсралт

А-247

ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ СТРАТЕГИ 2024-2030

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ СТРАТЕГИ 2024-2030.....

1. Нийтлэг үндэслэл	1
2. Стратеги боловсруулах хэрэгцээ шаардлага.....	1
3. Дэлхийн чиг хандлага	3
4. Ач холбогдол.....	5
5. Зорилго	6
6. Бодлогод баримтлах гол зарчим.....	6
7. Зорилтот бүлэг	6
8. Мэдлэг олгох сэдэв	7
9. Зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа.....	7
10. Стратегийг хэрэгжүүлэх хугацаа, удирдлага, зохион байгуулалт, тайлагнал	10
11. Үр дүнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээ	11

ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ СТРАТЕГИ 2024-2030

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал нь иргэдийн санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг бататгах, бүх нийтийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, санхүүгийн зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зөрчил, гэмт хэрэг багасах зэрэг нягт уялдаатай зорилтуудыг хэрхэн ханганд хэрэгжүүлж байгаагаар тодорхойлогддог. Эдгээрийн нэг болох иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх нь тухайн иргэний нас, хүйс, боловсрол, орлогын түвшин зэргээс хамаарахгүйгээр тэдний амьдралын чанарт чухал давуу талуудыг бий болгож байдаг. Учир нь хувь хүний санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг оновчтой сонгох, зөв хэрэглэх мэдлэг, ур чадвар нэмэгдсэнээр санхүүгийн аливаа эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн тогтвортой байдлаа хангах боломжийг нэмэгдүүлдэг. Санхүүгийн мэдлэг, хэрэглээний ур чадвар нь тухайн хувь хүнд, түүний гэр бүлийн гишүүд, бусад хүрээллийн санхүүгийн шийдвэр гаргалтад эргээр нөлөөлж, амьдралын зорилгод хүрэхэд нь цаашлаад эдийн засгийн болон нийгмийн эрүүл мэндэд чухал ач холбогдолтой.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратегийг хэрэгжүүлэх нь оролцогч талуудын хамтын ажиллагааны тэнцвэртэй байдлыг хангаж, авч буй арга хэмжээ, үйл ажиллагааны давхардлыг арилгах, нэн тэргүүний шаардлагатай арга хэмжээнд төвлөрөх боломжийг олгох зэрэг давуу талтай. Тус стратеги хэрэгжсэнээр иргэдийн санхүүгийн сахилга батыг сайжруулах, санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг дээшлүүлэх, урт хугацаанд хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэлийг бататгах, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжлийг дэмжих боломжийг бүрдүүлнэ.

2. СТРАТЕГИ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

2022 онд Монгол Улсын 21 аймаг, нийслэлд 15-69 насны 1947 хүнийг хамруулсан санхүүгийн боловсролын чадамжийн түвшинг тогтоох судалгааны үр дүнд иргэд, олон нийтийн санхүүгийн боловсролын чадамжийн дундаж түвшин 9.9 оноо буюу авч болох боломжит хамгийн өндөр оноо (20)-ны 49.5%-д байна. Улмаар тус түвшин нь Улаанбаатар хот (10.3) болон Хөвсгөл (11.5), Дархан-Уул (11.1), Булган (11.1), Ховд (10.9), Дорноговь (10.5), Сүхбаатар (10.3), Сэлэнгэ (10.2), Увс (10.2), Завхан (10.0), Баянхонгор (10.0) аймгуудад улсын дунджаас илүү өндөр оноотой байна.

- Санхүүгийн мэдлэг:** Судалгаанд оролцсон нийт иргэдийн санхүүгийн мэдлэгийн дундаж оноо боломжит 9 онооноос 4.7 буюу 52.1% байна. Үүнд Gen Z буюу 1995 (зарим тодорхойлолтоор 2000) оноос хойш төрсөн үеийнхэн бусад насны ангиллаас илүү 5.2 оноотой (58.2%) байсан бөгөөд нас ахих тусам санхүүгийн мэдлэг буурч байв.

Эх сурвалж: Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа, “Санхүүгийн Хүргээмж-Хөгжил Санаачилга” ТББ, 2022

- **Санхүүгийн хандлага:** Улсын хэмжээнд санхүүгийн хандлагын дундаж оноо 2.25 байгаа нь нийт авбал зохих 4 онооны 56.3% байна. Үүнд 11 аймгийн үр дүн улсын дунджаас өндөр байсан бол Улаанбаатар хот (2.1) улсын дунджаас доогуур байв.

OECD-ээс 2021 онд хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүн орнуудад хийсэн санхүүгийн боловсролын судалгаанд Төв Азийн бүс буюу Казакстан, Узбекстан, Киргиз, Тажикстан зэрэг улсын санхүүгийн боловсролын чадамж тус бүр 59.6%, 59.9%, 55.4%, 51.1% байсан бөгөөд Төв Азийн бүсийн улсын санхүүгийн боловсролын дундаж 56.5% байсан нь манай улстай харьцуулахад 7.0%-аар өндөр үзүүлэлт юм.

Судалгаанд оролцсон иргэдийн 70.3% нь мөнгө, санхүүгээ удирдах өөрийн чадвартаа итгэлтэй байдаг хэмээн хариулсан боловч бодит байдал дээр тэдгээр иргэдийн санхүүгийн, эдийн засгийн мэдлэг болон санхүүгийн зөв хандлага хангалтгүй буюу 49.5%-тай байна. Үүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг дурдвал:

- Орлого нь зарлагaa нөхөж чадахгүй байгаатай холбоотойгоор иргэдийн 67.5%-д ямар нэгэн байдлаар хоол хүнс болон бусад хэрэгцээгээ хангахад нь асуудал тулгардаг ба энэхүү асуудлаа шийдвэхийн тулд хэн нэгнээс мөнгө зээлэхэд хүрдэг.
- Санхүүгийн байгууллагуудын өргөн хүрээний үйлчилгээний талаарх мэдлэг нь арилжааны банкны зээл, хадгаламжаар л хязгаарлагдаж байна.
- Бусад мэдлэг, хандлагаасаа эдийн засгийн мэдлэг хамгийн тааруу гэсэн үр дүн гарсан. Үүнээс иргэд макро, микро эдийн засгийн нөхцөл байдалд тулгуурлан санхүүгийн хувьд хариу үйлдэл, зөв шийдвэр гаргаж чаддаггүй гэх дүгнэлтэд хүрч байна.

Мэдлэгийг багц хөтөлбөртэй сургалтаар дамжуулж авах, эсвэл санхүүгийн байгууллага үйлчилгээ үзүүлэхийн зэрэгцээ нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэглэгч нартаа санхүүгийн боловсрол олгох замаар иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх боломжтой гэж дүгнэсэн.

Мөн мөнгөний худалдан авах чадварт инфляц нөлөөлөх тухай асуултад судалгаанд оролцогчдын 38.9%, даатгалын бүтээгдэхүүний талаарх асуултад 70.5% нь тус тус зөв хариулсан байна. Судалгаанд оролцогчдын 63.0% нь хувьцааны талаар зөв хариулсан хэдий ч эрсдэл ба өгөөжийн тухай ойлголт 50.3%, эрсдэлийг тархаан байршуулах тухай ойлголт 44.7%, хамгийн эрсдэлтэй хөрөнгө оруулалтын тухай ойлголт 42.9% байв. Үүнээс харахад судалгаанд оролцогчдын хүү болон хувьцааны талаарх зөвхөн анхан шатны буюу суурь асуултад илүү зөв хариулж, арай гүнзгий асуултад буруу хариулах хандлагатай байна. Мөн судалгаанд оролцогчдын 42.9% нь криптовалютыг хамгийн эрсдэл өндөртэй хөрөнгө оруулалт гэж оновчтой хариулжээ.


Хүснэгт 1 : Санхүүгийн мэдлэгийн асуултуудад зөв хариулсан байдал

САНХҮҮГИЙН МЭДЛЭГ		Зөв хариулт (%)
Асуулт 1	Мөнгөний худалдан авах чадварт инфляц нөлөөлөх нь	38.9%
Асуулт 2	Энгийн хүүгийн талаарх ойлголт	42.5%
Асуулт 3	Нийлмэл хүүгийн талаарх ойлголт	28.4%
Асуулт 4	Харьцуулах шийдвэр гаргалт	80.6%
Асуулт 5	Эрсдэл ба өгөөжийн талаарх ойлголт	50.3%
Асуулт 6	Даатгалын бүтээгдэхүүний талаар	70.5%
Асуулт 7	Хувьцааны талаарх ойлголт	63.0%
Асуулт 8	Эрсдэлтэй хөрөнгө оруулалт	Крипто валют
		Хувьцаа
		Бонд
		ХБҮЦ ³
		Үл хөдлөх хөрөнгө
		Үнэт эдлэл
Асуулт 9	Эрсдэлийн тархаан байршуулалтын талаарх ойлголт	44.7%

Эх сурвалж: Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа, “Санхүүгийн Хүртээмж-Хөгжил Санаачилга” ТББ, 2022

Сэдэв тус бүрийн үр дунг нэгтгэн харвал, улсын хэмжээнд санхүүгийн мэдлэг дунджаар 4.7 байгаа нь нийт авбал зохих 9 онооны 52.1% юм. Үүнд Улаанбаатар (5.1) хот болон Дархан (5.4), Хөвсгөл (5.3), Дорноговь (5.2), Баянхонгор (5.1), Дорнод (5.0), Ховд (5.0), Сэлэнгэ (4.9), Дундговь (4.8), Хэнтий (4.8), Увс (4.8) аймгууд улсын дунджаас дээгүүр байсан бол Баян-Өлгий (3.9), Архангай (3.9), Орхон (3.8) аймгууд хамгийн бага оноотой байна.

Зураг 1. Санхүүгийн мэдлэгийн улсын дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшин тогтоох судалгаа, “Санхүүгийн Хүртээмж-Хөгжил Санаачилга” ТББ, 2022

3. ДЭЛХИЙН ЧИГ ХАНДЛАГА

Санхүүгийн засгийн хямралтай холбогдуулан бодлого боловсруулагчдын түвшинд олон нийтийн санхүүгийн мэдлэгт анхаарах талаар илүү эрчимтэй ажиллаж эхэлсэн бөгөөд энэхүү хандлага нь олон улсын хэмжээний бодлогын баримт бичигт тусгагдах болсон. Санхүүгийн хямрал тохиовол зөвхөн нэг улс бус бус нутгийг хамрах эрсдэлтэй байдаг.

Тухайлбал, 2008 оны дэлхийн санхүүгийн хямрал нь олон нийтийн санхүүгийн мэдлэгийн хэрэгцээ шаардлагын хувьд "сургамж дагуулсан мөч" гэж үзвэл "COVID-19-ийн хямрал" нь болзошгүй эрсдэлээс сэргийлэх, хуримтлаалаа нэмэгдүүлэх, санхүүгийн мэдлэг, чадвараа ахиулахыг ухааруулсан. Өөрөөр хэлбэл сүүлийн үед хувь хүний болон өрхийн санхүүгийн оновчтой удирдлага, санхүүгийн суурь мэдлэгийн ач холбогдол улам бүр нэмэгдэж байна.

Олон улсын болон бус нутгийн хэмжээний Их 20 (G20)-ийн удирдагчид санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх бодлогыг чухалчлан авч үзэн улс орнуудын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчмуудыг 2012 онд баталсан. Санхүүгийн мэдлэг олгох стратегийг хэрэгжүүлдэг орнуудын тоо эрчимтэй нэмэгдэж байгаа бөгөөд 2012 оны байдлаар 26 орон санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байсан бол 2013 онд 46, 2015 онд 60 улс болж, улмаар 2023 онд 175 улс иргэддээ санхүүгийн боловсрол олгох арга хэмжээ, үйл ажиллагааг тогтмол зохион байгуулдаг болжээ.

Иргэд санхүүгийн мэдлэгтэй байх нь тухайн улс орны эдийн засгийн хөгжлийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй бөгөөд санхүүгийн боловсролыг тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангах нөхцөлийг бүрдүүлэгч хэмээн олон улсын түвшинд тодорхойлж, ач холбогдол өгч байна. Дэлхийн улс орнууд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үндэсний стратеги боловсруулан ажиллаж байгаа хэдий ч өнөөдрийн байдлаар дэлхийн залуучуудын (15-24 насны) хагас нь санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг авч чадахгүй байна. Иймд санхүүгийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхийн тулд цахим санхүүгийн үйлчилгээг нэвтрүүлэх, түүнийг сурталчлан таниулах нь зарим тулгамдаж буй асуудлыг шийдэх боломжтой гэж олон улсад үзэж байна.

Сүүлийн үед технологийн дэвшлийг ашиглан Финтек компаниуд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг шинэ шийдлээр олон нийтэд түгээж эхэлж байгаатай холбогдуулан олон улсад санхүүгийн боловсролыг олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагууд мөн адил дижитал байдлаар санхүүгийн мэдлэгийг олгох мэдээ, мэдээллийг түгээж эхлэхээр өөрсдийн стратегидаа оруулсан байна. Жишээ нь:

- Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмж болон санхүүгийн мэдлэгийг түгээх зорилгоор бүх төрлийн цахим хуудсаар дамжуулж мэдээ, мэдээлэл болон сургалтыг зохион байгуулах;
- Санхүүгийн боловсролын хөлөгт тоглоомуудыг боловсруулах, түгээх;
- Гар утасны апликацийн бүтээн нэвтрүүлж, хувийн болон өрхийн төсвийг хөтлүүлэх.

Мөн интернэт, гар утас зэрэг дижитал төхөөрөмжөөр дамжуулан үзүүлж буй уламжлалт бус санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдлэгтэй, хэрэглээний чадвартай байх шаардлага үүссэн гэдгийг олон улсад хүлээн зөвшөөрч эхэлсэн. Уламжлалт бус санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг дараах 4 байдлаар ангилана. Үүнд:

1. Төлбөр тооцоо: Цахим мөнгө, цахим хэтэвч, виртуал хөрөнгө, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ;
2. Хөрөнгийн менежмент: Интернет банк, онлайн брокер, крипто арилжаа, хувийн санхүүгээ удирдах аппликашн,
3. Уламжлалт бус санхүүгийн хэрэгсэл: Crowdfunding, peer-to-peer (P2P) зээл, бичил зээл,
4. Бусад: Интернетэд суурилсан даатгалын үйлчилгээ гэх мэт.

Дэлхийн улс орнууд санхүүгийн мэдлэгийг аль болох бага нааснаас нь олгоход ихээхэн анхаарч, ач холбогдол өгч ажиллаж байна. 2023 онд эдгээр улс орнуудын 29 нь ЕБС-ийн цөм хөтөлбөрт санхүүгийн боловсролын хичээлийг заавал болон сонгох судлах байдлаар оруулсан. Тухайлбал, АНУ, Их Британи, Канад, Япон, Малайз, Индонез, Тайван зэрэг улсад санхүүгийн мэдлэг олгох сургалтын агуулгыг нийгмийн ухаан, тоо, түүх, газар зүй зэрэг хичээлийн агуулгад оруулсан байдаг. Зарим тохиолдолд тусад нь бие даасан судлагдахуун хичээл болгосон туршлагууд ч бий.

Санхүүгийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн улсын Төв банк болон Сангийн яам гол үүргийг гүйцэтгэдэг. Жишээ нь томоохон эдийн засагтай, хөгжингүй орнууд болох Канад, АНУ, Их Британи, ОХУ, Япон зэрэг улсад Төв банк нь иргэдэд санхүүгийн боловсрол олгох хөтөлбөрийг хариуцан ажилладаг. Дээрх улсууд санхүүгийн боловсролын хөтөлбөртөө дараах сэдвийг чухалчлан багтаасан. Үүнд:

1. Канад – хувийн санхүү, үнэт цаас болон хөрөнгийн зах зээл, ипотек
2. АНУ - хувийн санхүү, төв банк, мөнгөний тухай ойлголт
3. Их Британи – инфляц, мөнгөний тухай ойлголт, бичил зээл
4. ОХУ – дижитал байдлаар санхүүгийн боловсрол түгээх, финтек, инфляц
5. Япон - хувийн санхүү, мөнгөний тухай ойлголт, өрхийн төсөв

4. АЧ ХОЛБОГДОЛ

Иргэдийн санхүүгийн мэдлэг, хэрэглээний чадвар сайжрах нь эдийн засгийн бодит өсөлт болон ядуурлыг бууруулахад чухал нөлөөтэйгөөс гадна хэрэглэгчид, санхүүгийн үйлчилгээний салбар, Засгийн газар, Төв банк, бусад санхүүгийн зохицуулах үүрэг бүхий байгууллагууд, боловсрол олгогчид, ажил олгогч, ажилтан болон сайн дурын байгууллагууд зэрэг олон оролцогч талуудад ашиг тусаа өгдөг.

Санхүүгийн боловсрол нэмэгдсэнээр дараах гол үр дүн гарна. Үүнд:

- Иргэдийн мэдлэг, хэрэглээний чадвар дээшилснээр санхүүгийн бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэнэ;
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох, зориулалтаар нь ашиглаж үр өгөөж хүртэх боломжтой болно;
- Санхүүгийн залилан, мэхлэлтээс урьдчилан сэргийлж, түүнд өртөх иргэдийн тоо буурна;
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, өр багасна;

- Хөрөнгийн зах зээлд оролцох иргэдийн тоо өснө;

5. ЗОРИЛГО

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратегийн үндсэн зорилго нь i) санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих, ii) санхүүгийн зах зээлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, iii) эдийн засгийн өсөлтийг дэмжихэд оршино. Санхүүгийн мэдлэг олгох стратегийг Монголд өмнө нь хэрэгжүүлсэн бөгөөд олон улсын жишгээр өмнө нь авч байсан бодлогын арга хэмжээний үр дүн дээр үндэслэн дараа дараагийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлдэг жишгийг дагаж мөрдлөг болгоно.

6. БОДЛОГОД БАРИМТЛАХ ГОЛ ЗАРЧИМ

Санхүүгийн мэдлэг олгох бодлого боловсруулж хэрэгжүүлэхдээ нийгмийн сайн сайхан байдлыг дээд түвшинд хадгалахад чиглэсэн бодлогын хослол болгох бөгөөд ингэхдээ дараах олон улсын болон нийтлэг зарчмыг баримтална:

- Үндэсний хөгжлийн цогц бодлогын үзэл баримтлалд тулгуурлах;
- Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл зэрэг эдийн засаг, санхүүгийн салбарын хөгжилтэй холбоотой гарсан бодлогын бусад баримт бичгүүдтэй уялдуулах, залгамж чанарыг хадгалах;
- Санхүүгийн мэдлэг олгох үйл ажиллагаа нь шударга, аливаа ялгаварлан гадуурхах асуудлаас ангид байх;
- Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангах;
- Олон улсын жишигт нийцсэн байх;
- Олон төрлийн арга хэрэгслээс үр ашигтайг сонгон ашиглах;
- Арга хэмжээг чухлаар нь эрэмбэлэн тогтоох;
- “Сургах мөчүүд” буюу гэрлэлт, хүүхэдтэй болох, тэтгэвэрт гарах зэрэг санхүүгийн чухал шийдвэр гаргах амьдралын мөчлөгийг харгалзан үзэх;
- Хүйсийн тэгш байдлыг харгалзах;
- Нөөцийг үр ашигтай зарцуулах;
- Өмнө авч хэрэгжүүлсэн арга хэмжээ дээр үндэслэх;
- Хэрэглэгчдэд зориулсан арга хэмжээг хэрэгжүүлэхээсээ өмнө шалгах.
- Иргэдийг санхүүгийн залилан, мөрийтэй тоглоомын хохирогч болохоос өөрийгөө хамгаалах чадвартай болгох;

7. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Олон улсын туршлагаас, олон төрлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратегийг хэрэгжүүлдэг. Гэвч стратегийг хэрэгжүүлэх нөөц бололцоо хязгаарлагдмал байдаг тул хамгийн үр нөлөө бүхий болон нэн шаардлага зорилтот бүлгийг сонгон хэрэгжүүлэх нь чухал юм.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратеги дараах 3 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжинэ. Үүнд:

1. Хүүхэд, залуус;
2. Олон нийт болон орон нутгийн иргэд;
3. Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл.

8. МЭДЛЭГ ОЛГОХ АГУУЛГА

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх стратегийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах гол агуулгад чиглэнэ. Үүнд:

- Санхүү, мөнгөн хөрөнгийн талаар суурь ойлголт;
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт;
- Хадгаламж;
- Зээл;
- Хэрэглээний зээл;
- Хөрөнгө оруулалт;
- Санхүүгийн эрсдэл;
- Даатгал;
- Нийгмийн даатгал болон татварын талаар ойлголт;
- Санхүүгийн үйлчилгээ, санхүүгийн байгууллагуудын талаар ойлголт;
- Финтек болон Виртуал хөрөнгө;
- Цахим мөнгө
- Санхүүгийн залилан
- Санхүүгийн бизнесийн онцлог
- Санхүүгийн эрсдэл, үр өгөөжийн харьцуулалт

9. ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

<i>Тэргүүлэх чиглэл</i>	<i>Мэдээлэл хүргэх суваг</i>	<i>Хөгжсүүлэлтийн хэрэгслүүд</i>	<i>Хэрэгжсүүлэх үйл ажиллагаа</i>
Хүүхэд, залуус	<ul style="list-style-type: none"> - Уулзалт - Гарын авлага - Танхимиын сургалт - Цахим, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулах сургалт - Мөнгөний музейн сургалт - Сургагч багш бэлтгэх сургалт - Идэвхжүүлэлтийн арга хэмжээнүүд /Олон нийтийн санаа, санал, цаашид шаардагдах 	<ul style="list-style-type: none"> • Нэгдсэн стандарт танилцуулга /PPT/ • Тогтмол шинэчлэгдэх статистик инфографик • Гарын авлага • Сурах бичиг • Багшийн ном • Дасгал ажлын ном • Цахим материал • Цахим контент бэлтгэх 	<ul style="list-style-type: none"> • Боловсрол, шинжлэх ухааны яаманд ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулахад техникийн туслаалцаа үзүүлэх болон хамтарч ажиллах; • Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран багш бэлтгэдэг их дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт санхүүгийн боловсролын

	<p>сэдвүүдийг тодорхойлох зорилготой/</p> <p>- Оюутны өдөр / Хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын удирдлагуудтай хийх уулзалт/</p> <p>- Сурган хүмүүжүүлэгч нарын өдөр</p>		<ul style="list-style-type: none"> хөтөлбөрийн агуулгыг оруулах Санхүүгийн боловсролын хөтөлбөрийг олон улсад хэрэгжүүлэгч шилдэг туршлагатай олон улсын байгууллагуудын багш мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж дотоодын сургагч багш нарын чадварыг нэмэгдүүлэх хамтарсан сургалт зохион байгуулах Телевизийн хүүхдийн нэвтрүүлгийн хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах; Санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх талаар хүүхдийн нэвтрүүлэг бэлдэж буй сэтгүүлчдийг сургалтад хамруулах, чадавхыг нэмэгдүүлэх; Шинэ, залуу гэр бүлд санхүүгийн мэдлэг олгох сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагаар дамжуулан хийх;
Олон нийт болон орон нутгийн иргэд;	<p>-Сургалт</p> <p>-Олон нийтийн сүлжээ</p> <p>-Сургагч багш нарыг бэлтгэх</p> <p>- Гарын авлага</p>	<ul style="list-style-type: none"> Сургагч багш нарын хүртээмжийг нэмэгдүүлэх Сургалтын арга зүйг боловсруулах <p>Мэдлэг түгээх орон нутаг дахь харилцаа холбоог байнгын идэвхтэй үйл ажиллагаагаар удирдах</p>	<ul style="list-style-type: none"> Мэдлэг олгох сургалтын арга зүйг шинэчлэн стандартчлах Орон нутгийн төрийн захиргааны төв байгууллагын хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд санхүүгийн мэдлэг олгох арга, хэмжээнүүдийг тусгах Орон нутаг дахь төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах

			<ul style="list-style-type: none"> Орон нутагт сүлжээ, салбартай сургалтын байгууллагуудтай хамтарч ажиллах Сургагч багшаар бэлтгэх боломжит оролцогчдын судалгаа хийх
Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл	<p>-Олон нийтийн сүлжээ, ХМХ-ээр мэдээлэл түгээх</p> <p>-Цахим сургалт</p> <p>- Цахим хуудас</p> <p>- Видео хичээл</p> <p>-Цахим контент бэлтгэх</p>	<ul style="list-style-type: none"> Олон нийтийн эдийн засгийн мэдлэгийг нэмэгдүүлэх стратегийг хамтын ажиллагаат байгууллагуудтай хамtran хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүнг тооцдог байх Мэдлэг түгээх хүртээмжийг нэмэгдүүлэх Сургалтын заах аргачлалыг тогтоох 	<ul style="list-style-type: none"> Энгийн ойлгомжтой агуулгыг тодорхойлох Сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлэх Санхүүгийн боловсролын www.sankhuuvgiiinbolovsrog.l.mn цахим хуудсыг баяжуулах; Санхүүгийн тооцоолол хийх аппликацийн болон мэдлэг олгох хөгжөөнт тоглоомууд нэвтрүүлэх, санхүүгийн боловсролыг дэмжих нэгдсэн цахим хуудсанд байршуулах; Мөн тухайн цахим хуудсаараа дамжин иргэдээс тогтмол санал асуулга авч, шаардлагатай мэдээллийн агуулгыг тодорхойлох. Телевиз, сонин, сэтгүүл, радио гэсэн уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй санхүүгийн боловсрол олгох зорилготой нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэн явуулах талаар хамtran ажиллах; Санхүүгийн суурь мэдлэг олгох видео хичээлүүдийг цувралаар нэгдсэн цахим хуудас, сошиал сувгуудаар дамжуулан түгээх ПРТВ-г ашиглаж, видео санд санхүүгийн

			<ul style="list-style-type: none"> • мэдлэгийн тусгай цэс нээн ажиллуулна. • Кино контентоор дамжуулж, санхүүгийн мэдлэг олгох төсөл хэрэгжүүлнэ.
--	--	--	---

10. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТАЙЛАГНАЛ

1. Стратегийг 2024-2030 онд хэрэгжүүлнэ.
2. Монголбанк нь Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпорац, Боловсрол, шинжлэх ухааны яам, Монголын банкны холбоо болон бусад дэмжигч байгууллагуудтай хамтран ажиллана.
3. Стратегийг хэрэгжүүлэхэд оролцогч талууд дараах байдлаар хамтарч ажиллана.
Үүнд:
 - Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх;
 - Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх, ивээн тэтгэх;
 - Олон улсын туршилага судлах, хөтөлбөрийн оролцогчид болон сургагч багш нарыг чадавхжуулах олон улсын хэмжээний үйл ажиллагааг хамтран зохион байгуулах;
 - Судалгаа, шинжилгээ хийх болон техникийн туслалцаа үзүүлэх;
 - Сургалт зохион байгуулах, чадавхыг бэхжүүлэхэд хамтарч ажиллах;
 - Стратегийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээг хийхэд хамтарч ажиллах;
 - Нөөц бололцоо, мэдээ, мэдээлэл зэргийг үр ашигтайгаар хуваан ашиглах;
 - Хамтран ажиллах боломжтой бусад байгууллагуудыг үйл ажиллагаандаа татан оролцуулах.
4. Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлд шинэ нөхцөл, байдал үүссэн тохиолддолд стратегийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн баталж болно.
5. Стратегийн биелэлтийг жил бүр хамтран ажиллаж буй байгууллагуудын жилийн тайландаа багтаан олон нийтэд танилцуулна.

11. ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Хяналт, шинжилгээ, үнэлгээг нэгдсэн төлөвлөгөөнд үндэслэн хийх бөгөөд зохих зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Үр дүнг үнэлэхдээ стратеги нь зорилтот бүлэгт хүрч санхүүгийн мэдлэгийн түвшин нэмэгдсэн эсэх болон нөөцийг үр ашигтай зарцуулсан эсэхэд хяналт үнэлгээг төвлөрүүлэн хийнэ.